



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2009 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

**“Алтанхоромсог” БДК-ийн
тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх
тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Брокер, дилерийн “Алтанхоромсог” хязгаардлагдмал хариуцлагатай компанийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2009 оны 2 дугаар сарын 19-ны өдрөөс эхлэн 1 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Түдгэлзүүлсэн хугацаанд иргэн М.Хумарын 25-19438 тоот дансанд “Багануур” ХК-ийн 756 ширхэг хувьцааг 2009 оны 3 дугаар сарын 19-ны дотор буцаан байршуулж, хохиролгүй болгох арга хэмжээ авахыг “Алтанхоромсог” ХХК /Т.Мөнхор/-т даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ